



VI/2022


Тархаасан: 2022 оны 7 дугаар сарын 18



Үнэмлэхүй их температур 2022 оны 6 дугаар сард Баянхонгор аймгийн Шинэжинст суманд +40.3 °C-д хүрсэн байна

Агаарын үнэмлэхүй их температур 2022 оны 6 дугаар сард Баянхонгор аймгийн Шинэжинст суманд +40.3°C, үнэмлэхүй бага температур Завхан аймгийн Цэцэн-Уул суманд -6.0°C-д хүрлээ.

ЗУРАГ 1. АГААРЫН ТЕМПЕРАТУР (°C), олон жилийн дундажтай¹ харьцуулснаар, станцын байршлаар, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар



¹ - Сүүлийн 30 жил

Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр 2022 оны 6 дугаар сард орсон хамгийн их хур тунадасны нийлбэр хэмжээ Хэнтий аймгийн Дадал суманд 195.2 мм-т хүрсэн байна. Үнэмлэхүй их салхины хурд Хэнтий аймгийн Хэрлэн суманд 31 м/с-д хүрсэн байна.

Агаарын чанар

Азотын давхар ислийн сарын хамгийн их агууламж 2022 оны 6 дугаар сард Тахилт, 13 дугаар хороолол, Баруун дөрвөн зам орчимд 0.051 мг/м³-0.069 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.001 мг/м³-0.019 мг/м³-ээр буюу 2.0-38.0 хувиар давсан байна.


PM 10 тоосонцрын сарын хамгийн их агууламж 2022 оны 6 дугаар сард Толгойт, Баруун дөрвөн зам, Таван буудал, Амгалан, Хайлааст, Мишээл экспо төв, Тахилт, Богд хааны ордон музей, Ургах наран хороолол, Нисэх, 13 дугаар хороолол, Баянхошуу, Зуун айл, Цахилгаан станц

орчимд 0.019 мг/м³-0.240 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.009 мг/м³-0.230мг/м³-ээр буюу 90.0 хувиас 24.0 дахин давсан байна.

PM 2.5 тоосонцрын сарын хамгийн их агууламж 2022 оны 6 дугаар сард Таван буудал орчимд 0.052 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.002 мг/м³-ээр буюу 4.0 хувиар давсан байна.

Улаанбаатар хотын агаар дахь PM 10 тоосонцрын дундаж агууламж 2022 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.009 мг/м³ (21.0%)-өөр, PM 2.5 тоосонцрын дундаж агууламж 0.003 мг/м³ (24.9%)-аар их байсан бол азотын давхар ислийн дундаж агууламж 0.001 мг/м³ (3.2%)-ээр, хүхэрлэг хийн дундаж агууламж 0.001 мг/м³ (5.8%)-ээр тус тус бага байна.

ЗУРАГ 2. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСУУДЫН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар, мг/м³



Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2022 оны эхний хагас жилийн байдлаар 2304 болж, өмнөх оны мөн үеэс 289 (14.3%) -өөр өссөн байна. Газар хөдлөлт 2022 оны эхний хагас жилийн байдлаар 32 удаа бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 210 (86.8%) -аар буурсан байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 99 хүн амь насаа алдаж, өмнөх оны мөн үеэс 16 (13.9%) -гаар буурсан байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны эхний хагас жилийн байдлаар 10.2 тэрбум төгрөгийн хохирол учирч, 2.1 тэрбум төгрөг зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 1. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ², жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Үзүүлэлт	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2022 I-VI	2022 I-VI 2021 I-VI
					хувь
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	2 968	2 472	2 015	2 304	114.3
Газар хөдлөлтийн тохиолдлын тоо	21	32	242	32	13.2
Объектын түймрийн тоо	2 561	1 932	1 382	1 781	128.9
Амь насаа алдсан хүний тоо	112	99	115	99	86.1
Учирсан хохирол, тэрбум төгрөг	6.4	105.3	10.6	10.2	96.2
Зарцуулсан зардал, сая төгрөг	1 045.8	173.5	975.2	2 126.7	2.2 ¹

² - Корона вируст халдварын тохиолдлын тоо болон түүнтэй холбоотой гарсан зардлыг оруулаагүй.

Ойлголт, тодорхойлолт

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



Эх үүсвэр:

Цаг уур, орчны шинжилгээний газар;
Онцгой байдлын ерөнхий газар;

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархах хуваарь:

2022 оны 8 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн
газрын дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн
газрын ахлах статистикч Б.Уянгаа
Утас : (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212